

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВӨӨС ЭРГЭН
ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕССЫН “БАРИХ-
ШИЛЖҮҮЛЭХ” ТӨРЛӨӨР ХЭРЭГЖСЭН “АГЛАГ
БҮТЭЭЛИЙН ХИЙД ХҮРТЭЛХ 6.2 КМ ХАТУУ
ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

**Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл**
Утас: 263755, цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитын менежер Б.Саруул
Утас: 261805, цахим хаяг: saruulb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Болормаа
Утас: 261456, цахим хаяг: bolormaab@audit.gov.mn

Аудитор М.Доржмаа
Утас: 261456, цахим хаяг: dorjmaam@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар
Утас: 261456, цахим хаяг: [naranbaatarsh@audit.gov.mn](mailto:baranbaatarsh@audit.gov.mn)



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 18 өдөр

Дугаар A/86

Улаанбаатар хот

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн “Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Үндэсний хөгжлийн газар /Б.Баярсайхан/-т тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар тогтоосон акт, өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т, аудитын тайлан, ажлын баримтыг 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Б.Болормаа/-т тус тус үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
АЗБХЗГ	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
БХТ	Барилгын хөгжлийн төв
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.7 дахь хэсэгт “Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах” гэж заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/53 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1¹, 6.3.3² дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад ажлын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад хууль, эрх зүйн шаардлагыг хангасан төслийг тусгаж, концесс эзэмшигчийг хуулийн дагуу сонгон шалгаруулсан эсэх;
- Концессын төслийн гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх гэсэн дэд зорилтуудын хүрээнд гүйцэтгэв.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл, хамарсан хүрээ:

Дүгнэлт гаргах ажилд Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт (300), Төрийн аудитын стандарт MNS6817:2020, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, “Хансуун зам” ХХК, зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн хуулийн этгээд, концесс эзэмшигч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан, дээрх байгууллагуудаас төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой баримтуудыг гаргуулан авч, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах горимыг ашиглан нотлох зүйл цуглуулж, баримтжуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Үндэсний хөгжлийн газраас 2015 онд концесс эзэмшигч “Хансуун зам” ХХК-тай байгуулсан “Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн гэрээний хэрэгжилтэд хийсэн аудитад хөндлөнгийн мэргэжлийн байгууллагыг шинжээчээр оролцуулж, концессын зүйлийн зураг төслийн боловсруулалт, баталгаажуулалт, зөвлөхийн хяналт, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн дүгнэлт гаргуулсан бөгөөд түүнд тулгуурлан аудитын үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

¹ шалгаагдагч этгээдэд ... санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

² төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохирхой асуудлаар аудит хийх;

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Концессын тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг;
- Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам";
- Төрийн өмчийн хороо (хуучин нэрээр)-ны 2010 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал";
- Сангийн сайдын 2016 оны 415, 2017 оны 273 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам";
- Засгийн газар болон "Хансуун зам" ХХК-ийн хооронд 2015 онд байгуулсан "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн "барих-шилжүүлэх" концессын гэрээ;
- Авто замын салбарт мөрдлөг болгож буй норм, дүрэм, стандартууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Болормаа, аудитор М.Доржмаа, Ш.Наранбаатар нар гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх зорилгоор "Өлзий бадруулагч хийд" чиглэлд дэд бүтэц бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна

Монгол Улсад аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх, шашин соёл, урлагийн түүхэн үнэт бүтээн байгуулалтыг гадаад, дотоодын жуулчид, ард иргэдэд сурталчлан таниулах зорилгоор иргэн Г.Пүрэвбат Төв аймгийн Борнуур сумын Нарт багийн Далийн аманд байрладаг газар "Аглаг бүтээлийн хийд"-ийг 2010 онд үүсгэн байгуулсан байна.

Тус хийдэд байрлах урлаг соёлын бүтээлийг сонирхон үзэх иргэд Улаанбаатар-Дархан чиглэлийн улсын чанартай авто замын 92 дахь км-ээс "Аглаг бүтээлийн хийд" рүү 6.2 км байгалийн шороон замаар явж очдог байжээ.

Тухайн зам нь бороо, үер усны нөлөөгөөр эвдэрч, бартаа саад ихээр үүссэн, иргэд автомашинаар зорчих боломж хязгаарлагдмал байснаас шалтгаалж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим муутай байсан тул шинээр хатуу хучилттай авто зам барих хэрэгцээ шаардлага бий болсон байна.

"Аглаг бүтээлийн хийд"-ийн тэргүүн Г.Пүрэвбат болон "Хансуун зам" ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Ууганзаяа нар 2013 онд "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж, Улаанбаатар хотоос Дархан орох 98 дахь км-ээс Аглаг бүтээлийн хийд хүртэл 7 км хайрган хучилттай авто зам барих ажлыг эхлүүлжээ.

Нэг. АУДИТЫН ДҮН

Орон нутгийн шинж чанартай авто замын ажлыг зардал, ашгийг тооцолгүйгээр төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлуулжээ

1.1 Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоолд өөрчлөлт оруулахаар Хөрөнгө оруулалтын газраас /хуучин нэрээр/ санал оруулсны дагуу Засгийн газрын 2015 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 306 дугаар тогтоолоор "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 7 км авто замын ажил"-ыг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж оруулсан байна.

1.2 Авто замын тухай хуулийн /2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсон/ 3 дугаар зүйлийн 3.1.9-д "орон нутгийн чанартай авто зам" гэж нийслэл, аймгийн нутаг дэвсгэр дэх сум, дүүрэг, хот, суурин газрыг хооронд нь холбосон авто замыг" ойлгоно гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Нарт багийн нутаг дэвсгэрт баригдсан уг зам нь орон нутгийн шинж чанартай авто замд хамаарч байна.

1.3 Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/ нь Концессын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1³, 9 дүгээр зүйлийн 9.4⁴-т заасны дагуу тус авто замын хэрэгцээ шаардлага, нийгэм эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлоогүй, зардал ашгийн тооцооллыг гаргаагүй байна.

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангаагүй байхад концесс эзэмшигчтэй "шууд гэрээ" байгуулсан нь хуульд нийцэхгүй байна

1.4 "Аглаг бүтээлийн хийд"-ийн тэргүүн Г.Пүрэвбатаас Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/-т Аглаг бүтээлийн хийд рүү тавих 6.2 км авто замын ажлыг "Хансуун зам" ХХК-иар шууд гэрээгээр гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдөр албан бичгээр ирүүлсэн байна.

1.5 Засгийн газрын 2015 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 306 дугаар тогтоолоор "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 7 км авто замын ажил"-ын концесс эзэмшигчийг "уралдаант шалгаруулалт явуулах" замаар сонгон шалгаруулахаар шийдвэрлэснийг Засгийн газрын мөн оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 334 дүгээр тогтоолоор "шууд гэрээ байгуулах", "барих шилжүүлэх" гэсний өмнө "зураг төсөл боловсруулах" гэж нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Хүснэгт 1. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгаасан төслийн мэдээлэл

Концессын зүйлийн нэр	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр дэмжлэг үзүүлэх эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах эсэх
Аглаг бүтээлийн хийд хүртэлх 7 км авто замын ажил	Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх	Авто замын ажлыг гүйцэтгэх	Судлан шийдвэрлэх	Шууд гэрээ байгуулах

Эх сурвалж: Засгийн газрын 2015 оны 306, 334 дүгээр тогтоолын хавсралт

1.6 Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "концесс олгох шийдвэр гаргаж, концессын гэрээ байгуулах эрхийг ... байгууллагад олгох" гэж тзаасан болон мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3⁵-т заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2015 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 379 дүгээр тогтоолоор "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 7 км авто замын ажил" төслийн 6,952.0 сая төгрөгийн үнийн

³ Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд ... өөрийн санаачилгаар концессын гэрээ байгуулах төслийн саналаа зардал, ашгийн тооцооны хамт төрийн өмчийн концессын зүйлийн хувьд концессын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ирүүлж болно".

⁴ Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ... концессын зүйлийн талаарх энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

⁵ 10.3-т Концессын зүйлийн жагсаалтад дараах зүйлийг тусгана: 10.3.1-д концессын зүйлийн нэр, тодорхойлолт, концессын төрөл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ; 10.3.2-т төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх.

дүнтэй концессын гэрээг “Хансуун зам” ХХК-тай байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/-т олгосон байна.

1.7 Ийнхүү Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1⁶-д заасан нөхцөл үүсээгүй байхад Засгийн газраас Концессын тухай хуулийн 6.1.1⁷ 10.1⁸-д заасныг үндэслэл болгон “Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто зам”-ын ажлыг гүйцэтгүүлэхэд “шууд гэрээ байгуулах” шийдвэр гаргажээ.

1.8 Засгийн газрын 2015 оны 379 дүгээр тогтоолыг үндэслэн Хөрөнгө оруулалтын газраас /хуучин нэрээр/ 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр “Хансуун зам” ХХК-тай 6,952.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий “Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээг байгуулсан байна.

1.9 Хөрөнгө оруулалтын газраас /хуучин нэрээр/ концессын гэрээ байгуулахдаа 7 км авто зам гэснийг 6.2 км болгож, 0.8 км-ээр багасгасан, Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 334 дүгээр тогтоолоор “барих шилжүүлэх” гэсний өмнө “зураг төсөл боловсруулах” гэж нэмэлт оруулсныг концессын гэрээнд тусгаагүй зэрэг шалтгааны талаар Үндэсний хөгжлийн газарт “тус газар нь өөрчлөн байгуулагдсан” гэснээс өөр тайлбар байхгүй байна.

1.10 “Хансуун зам” ХХК нь концессын гэрээний дагуу төслийг 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө ашиглалтад оруулах үүрэг хүлээсэн боловч 3 жил гаруй хугацааны дараа буюу 2019 оны 7 дугаар сарын 26-ны өдөр барьж дуусгажээ.

1.11 Концессын гэрээний 1.11-д “Концесс эзэмшигч нь ...хөрөнгө оруулалтын эргэн төлөлт болох 6,952.0 сая төгрөгийг 2016 онд Монгол Улсын Засгийн газраас нөхөж авна” гэж заасан боловч концесс эзэмшигч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүйгээс тухайн онд хөрөнгө оруулалтыг эргэн төлөх нөхцөл үүсээгүй байна.

1.12 Үүнээс үзвэл, Концессын гэрээнд авто замын барилга, байгууламжийг улсын комисс хүлээн авах, Төсвийн тухай хуульд тусгаж батлуулсны дараа санхүүжилтийг олгох гэх мэт хуулиар хийгдэх ажилбар, шаардлагуудыг харгалзахгүйгээр хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн санхүүжилтийг олгох хугацааг тусгасан байна.

Авто замын зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн шаардлагын дагуу боловсруулсан байна

1.13 Төв аймгийн Засаг даргын 2015 онд баталсан 15/03 дугаартай “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Аглаг бүтээлийн сүм хүртэлх авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах зургийн даалгавар”-ын дагуу “Аглаг бүтээлийн хийд чиглэлийн 6.2 км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, ажлын тоо хэмжээг “Эн Би Си Си” ХХК-ийн эксперт Н.Батсуурь, төсөвт өртгийг эксперт А.Сэлэнгэ 6,952.0 сая төгрөгөөр үнэлж, “Зам, тээврийн хөгжлийн төв”-ийн 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 009/2015 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

1.14 Батлагдсан зураг төсвийн дагуу тус замын эхний хэсгийн 5.6 километр авто замыг 20 сантиметр буталсан чулуун суурь бүхий 6 сантиметр зузаан асфальт бетон хучилттай, 7 метрийн өргөн 2 эгнээ зорчих хэсэг, хоёр талдаа 2 метрийн өргөн хөвөө бүхий 3 дугаар ангиллын зам байх, төгсгөл хэсэгтээ автомашины зогсоолтой, хийд хүртэл чулуун хучилттай явган замтай байхаар төлөвлөжээ.

⁶ 17.1.Дор дурдсан тохиолдолд шууд гэрээ байгуулах аргаар концессыг олгож болно:17.1.1.уралдаант шалгаруулалт явуулах нь үндэсний аюулгүй байдлыг харшилна гэж үзсэн;17.1.2.концессыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай оюуны үнэт зүйлтэй холбоотой эрх нээ буюу нэгдмэл сонирхолтой этгээдийн өмчлөлд байгаа.

⁷ 6.1.1.Төсвийн тухай хуулийн 33.2.9-т зааснаас бусад төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг батлах;

⁸ 10.1.Төсвийн тухай хуулийн 33.2.9-т зааснаас бусад төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална.

1.15 Магадлалын ерөнхий дүгнэлтэд Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлын төсвийг холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн зохиосон, төсвийн тооцоо нь "Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын дагуу боловсруулагдсан гэж дурдсан байна.

1.16 "Хансуун зам" ХХК тус авто замын барилга угсралтын ажлын төсөвт магадлан итгэмжлэл хийх экспертийг томилж өгөх тухай хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн төвд 2018 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 02/150 дугаартай албан бичгээр хүргүүлжээ.

1.17 Зам, тээврийн хөгжлийн төв болон "Хансуун зам" ХХК-ийн хооронд 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдөр "Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын гэрээ" байгуулагдсаны дагуу "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто замын барилгын ажил"-ын төсвийг тэргүүлэх төсөвчин Д.Энхтуяа 6,949.0 сая төгрөг буюу гэрээний үнээс 3.0 сая төгрөгөөр бууруулан тооцож, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 112/2018 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг банк, аж ахуйн нэгж байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр бүрдүүлжээ

1.18 Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт "барих-шилжүүлэх" концесс гэж "концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх" гэж заасан байна.

1.19 Мөн концессын гэрээний 1.11 дэх хэсэгт "концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр санхүүжүүлэн, барьж дуусган холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээлгэн өгч, хөрөнгө оруулалтын эргэн төлөлт болох 6,952.0 сая төгрөгийг ... нөхөж авна" гэж заасны дагуу концесс эзэмшигч төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг БНХАУ-ын "Tianjin Metallurgy Group Import & Export" компанийн хөрөнгөөр санхүүжүүлэн, барьж дуусгахаар 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдөр концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.20 Гэвч хөрөнгө оруулагч БНХАУ-ын "Tianjin Metallurgy Group Import & Export" компани хөрөнгө оруулалт хийхээс татгалзсан бөгөөд концесс эзэмшигчээс хөрөнгө оруулагч солигдсон талаар Үндэсний хөгжлийн газарт албан ёсоор мэдээлээгүй байна.

1.21 "Хансуун зам" ХХК төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өөрчилж, Улаанбаатар хотын банк болон зарим аж ахуйн нэгж, байгууллагаас бүтээгдэхүүн зээлээр худалдан авах байдлаар бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2. Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн бүрдүүлэлт /сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Зээлийн гэрээний		
		дүн	эхлэх огноо	дуусгавар болох огноо
1	Улаанбаатар хотын банк	2,100.0	2016.11.21	2017.11.17
2	М-Ойл групп ХХК /Хөрөнгө оруулалтын гэрээ/	4,900.0	2016.03.10	2018.08.10
	ДҮН	7,000.0		

Эх сурвалж: Концесс эзэмшигчийн санхүүгийн баримт

1.22 Ийнхүү төслийн хөрөнгө оруулагч хуулийн этгээд өөрчлөгдсөн байхад концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гэрээний 6 дугаар зүйлийн 6.5-д "Төслийн санхүүжилт хуваарьт заасан хугацаанаас 2 сараар саатаж

авто замын барилга угсралтын ажил зогсоход хүрвэл Эрх бүхий этгээд нь ...гэрээг цуцлан дараагийн концесс эзэмшигчийг сонгох эрхтэй" гэж заасны дагуу хуульд заасан зохих арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Гүйцэтгэгч хуульд заасан хугацаанд хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэлийн тайланг эрх бүхий байгууллагад ирүүлээгүй байна

1.23 Концесс эзэмшигч нь төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг аж ахуйн нэгж, байгууллагаас зээл авах байдлаар бүрдүүлсэн бөгөөд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай шатахуун, бүтээгдэхүүн, материалыг зээлээр, тоног төхөөрөмжийг хувь хүн, байгууллагаас түрээслэн авч авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байна.

1.24 "Хансуун зам" ХХК нь төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг аль нэг арилжааны банканд данс нээж байршуулаагүй, төслийн санхүүжилтийг бэлнээр захиран зарцуулсан бөгөөд Концессын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.6-д *"Концесс эзэмшигч нь концессын гэрээний дагуу гарсан ашиглалт, гүйцэтгэлийг ... улирал бүр концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй"* гэж заасныг хэрэгжүүлээгүй, зардлын гүйцэтгэл, тайланг холбогдох хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад ирүүлээгүй байна.

1.25 Энэ нь Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.13⁹-т заасны дагуу концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулалтын ашиглалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг улирал бүр гаргуулан авах, хяналт тавих ажлыг хангалтгүй гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

1.26 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх "барих-шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт"-д дээрх төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд 2017 онд 6,952.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан байна.

1.27 Сангийн яамнаас "Улаанбаатар-Дарханы замаас Аглаг бүтээлийн хийд чиглэлд 6.2 км авто зам барих төсөл"-ийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн 6,952.6 сая төгрөгийн санхүүжилтийг 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Үндэсний хөгжлийн газрын дансанд шилжүүлсэн байна.

1.28 Энэ нь Засгийн газраас концесс эзэмшигчидтэй "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулсан гэрээний хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг төслийн санхүүжилтийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалт, улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авах хугацаа зэргийг харгалзаагүйгээс тухайн тайлант хугацаанд батлагдсан хөрөнгийг ашиглахгүй байх эрсдэл үүссэнээс шалтгаалсан байна.

1.29 Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн албан бичгийг үндэслэн Үндэсний хөгжлийн газраас төслийн эргэн төлөлтөд 2018 онд 2,165.8 сая төгрөгийг дор дурдсан байгууллагын дансанд 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдөр шилжүүлсэн байна. Үүнд:

- "Петростар" ХХК-ийн улсын төсөвт төлөх гаалийн албан татварт 1,301.0 сая төгрөгийг Гаалийн ерөнхий газрын дансанд;
- "Алютек Монголиа" ХХК-ийн дансанд 50.0 сая төгрөгийг;
- "Улаанбаатар менежмент" ХХК-ийн дансанд 814.8 сая төгрөгийг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 4141 дугаартай захирамжийн дагуу тус тус шилжүүлжээ.

⁹ 6.2.13.холбогдох журмын дагуу концесс эзэмшигчээс концессын гэрээний ашиглалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг улирал бүр гаргуулан авч, нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

1.30 Ийнхүү "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн санхүүжилтийн үлдэгдэл болох 4,786.2 сая төгрөг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Үндэсний хөгжлийн газрын барьцаа хөрөнгийн Төрийн сан дахь 100900008350 тоот дансанд байршиж байна.

Эрх бүхий байгууллагаас авто зам барих зөвшөөрлийг авч, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна

1.31 Төв аймгийн Борнуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 49 дүгээр тогтоолоор Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Нарт багийн Далын аманд байрлах "Аглаг бүтээл"-ийн сүм хүртэлх 6.2 км авто замын ажлыг шинээр гүйцэтгэж байгаатай холбогдуулан авто зам барих газрыг тогтоосон бөгөөд зам барилгын ажлын 06/14/2017 дугаартай зөвшөөрлийг Зам, тээврийн яамны /хуучин нэрээр/ АЗБХЗГ-аас 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаагаар олгосон байна.

1.32 Концессын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.3-т "Концесс эзэмшигч нь гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний чанар, тоо, хэмжээг концессын гэрээнд заасан хэмжээнээс бууруулахгүй байх" гэж заасан байна.

1.33 Аудитад хөндлөнгийн шинжээчээр ажилласан "Танил санаа" ХХК-ийн шинжээчдийн баг тус авто замын техник-ашиглалтын түвшин тодорхойлох хэмжилт, туршилтын ажлыг авто замын салбарт мөрдөж буй стандарт, норм дүрэм, аргачлалыг баримтлан хийж гүйцэтгэн, дүгнэлт гаргасан байна.

1.34 Хэмжилт судалгааны ажлын үнэлгээгээр "Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Аглаг бүтээлийн хийд чиглэлийн 6.2 км" асфальт бетон хучилттай авто замын техник ашиглалтын үзүүлэлтэд хэмжилт хийж, холбогдох норм стандарт, зураг төслийн шаардлагад **"нийцсэн"** гэж үнэлсэн байна.

1.35 Аудитаар "Хансуун зам" ХХК-ийн гүйцэтгэсэн "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн ажлын тоо хэмжээг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Авто зам уртын хувьд 5.67 км бөгөөд үлдсэн хэсэг нь чулуун хучилттай авто зам байхаар анх төлөвлөгдсөн боловч ажлын явцад замын төгсгөлийн дагуу налуу ихтэй тул 600 метр хэсгийг чулуун хучлагатай, цемент бетон шат бүхий явган хүний замтайгаар барьсан;
- Дархан чиглэлийн төв замтай уулзаж буй гурван замын уулзварын төлөвлөлт тусгайлан хийгдээгүй;
- Зургийн тоо хэмжээ зайлшгүй шаардлагаар өөрчлөгдсөн;
- Цахилгаан, гэрэлтүүлгийн ажлыг олгоогдсон техникийн нөхцөл, ажлын зургаар тодорхойлогдсон тоо хэмжээний дагуу цахилгааны норм үнэлгээгээр хяналтын төсөв тооцож, экспертээр хянуулж батлуулаагүй байна.

Хүснэгт 3. Авто замын зарим ажлын тоо хэмжээний өөрчлөлтийн мэдээлэл

Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ		Зөрүү
		ҮХГ-ын хянасан гүйцэтгэл	Шинжээчийн тооцоолол	
Ул хөрсийг тэгшилж нягтруулах	1м2	53,221.0	116,193.0	62,972.0
Явган хүний замын чулуун хучилт байгуулах	1м2	1,734.0	1,015.0	-719.0
Шуудууг чулуун өрлөг хийж бэхлэх	1м2	4,925.0	3,329.0	-1,596.0
Амсрын ул бетон цутгах	1м2	130.0	7.0	-123.0
1 үе чулуун бэхлэгээ хийх/ рейс/	1м2	1,451.0	728.0	-723.0
Бетон суурь байгуулах	1м3	75.0	65.0	-10.0

Эх сурвалж: Хөндлөнгийн шинжээчийн тайлан

1.36 Иймд дээрх ажлын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар тооцоолжээ. Үүнд:

Хүснэгт 4. Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл /сая төгрөг/

Концессын гэрээний дүн	Магадлалаар баталгаажсан төсөв	ҮХГ-ын хянасан гүйцэтгэл	Бодит гүйцэтгэл	Зөрүү
1	2	3	4	5=4-1
6,952.0	6,949.0	6,679.2	6,690.9	261.1

Эх сурвалж: Хөндлөнгийн шинжээчийн тайлан

1.37 Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл төслийн концессын гэрээний үнийн дүнгээс 261.1 сая төгрөг, эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан дүнгээс 11.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна.

Төслийн хэрэгжилтийг дүгнэж, үнэлгээ өгөөгүй байна

1.38 Концессын гэрээний 2 дугаар зүйлийн 2.6-д "Концесс эзэмшигч нь ... өөрийн хөрөнгөөр авто замын хяналтын зөвлөх үйлчилгээний компанийг томилон ажиллуулна" гэсний дагуу "Хансуун зам" ХХК нь авто замын барилгын ажилд хяналт хийлгүүлэх зорилгоор "Батглостер" ХХК-тай 39.5 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан байна.

1.39 Зөвлөх үйлчилгээний "Батглостер" ХХК нь чулуун зам болон, гэрэлтүүлгийн ажилд зөвлөгөө өгөх мэргэжлийн инженер техникийн ажилтангүй, үндсэн гэрээний хугацаа дууссан зэргээс шалтгаалж зөвлөх, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээг цуцлах хурлын шийдвэрт үндэслэн тус зам барилгын ажлын зөвлөхийн хяналтын гэрээ цуцлагдсан боловч тус компанид гэрээний хариуцлага тооцсон тухай баримт материал алга байна.

1.40 Ийнхүү концесс эзэмшигч 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зөвлөх үйлчилгээний "Эм Си Пи Си Жи Ар" ХХК-тай 120.0 сая төгрөгийн гэрээ байгуулснаар авто замын барилгын ажилд өдөр тутмын хяналт хийгдэж, гүйцэтгэгч компанийн инженер, техникийн ажилтан нартай ажлын талбайд хамтарсан үзлэг хийж ажилласан байна. Зөвлөх компани нь барилга угсралтын ажлын өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэхдээ төслийг зураг, түүний техникийн шаардлага, технологийн горимын дагуу хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд зам, замын байгууламжийн барилга угсралтын ажилд зөвлөхийн хяналтаас хамаарсан аливаа чанарын гологдол гарч, эвдрэл үүссэн зүйл одоогоор гараагүй байна.

1.41 Үндэсний хөгжлийн газраас Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д "Концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх" гэж заасны дагуу концессын гэрээний хэрэгжилтийг дүгнэж, зохих арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Нийгэм, эдийн засгийн ач холбогдол багатай, үр ашиг муутай төсөл, арга хэмжээг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусган хэрэгжүүлсэн байна

1.42 Үндэсний хөгжлийн газар болон "Хансуун зам" ХХК-ийн Зам, тээврийн хөгжлийн яаманд илгээсэн "Улаанбаатар Дарханы авто замын 92 дахь км-ээс Аглаг бүтээлийн хийд чиглэл"-ийн 6.2 км авто замыг ашиглалтад хүлээн авах улсын комиссыг ажиллуулж өгөх хүсэлтийн дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 421 дүгээр тушаалаар томилогдсон Ажлын хэсэг авто зам, замын байгууламжийн барилгын ажлын чанар, холбогдох баримт бичиг, материалуудтай танилцаж, газар дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийжээ.

1.43 Ийнхүү "Аглаг бүтээлийн хийд чиглэлийн 6.2 км хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр 2019 оны 9 дүгээр

сарын 10-ны өдрийн 10/05/19 дугаартай дүгнэлтээр тус авто зам, замын байгууламж нь зураг төсөл, техникийн шаардлагын дагуу бүрэн хийгдэж дууссан бөгөөд авто замыг үйлчилгээний зориулалтаар ашиглах шаардлагыг хангасан гэж үзэж, ашиглагч байгууллага болох Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын мэдэлд 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс ашиглалтад авахыг зөвшөөрсөн байна.

1.44 "Аглаг бүтээлийн хийд" чиглэлд хатуу хучилттай авто зам баригдсанаар аялал жуулчлалын бүс нутгийн зам харилцаа, дэд бүтэц сайжирч, тус чиглэлд зорчиж буй иргэд олон нийт болон гадаад, дотоодын жуулчдын тээврийн хэрэгслээр зорчих хөдөлгөөний аюулгүй байдал хангагдсан байна.

ХОЁР. ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төслийн хөрөнгө оруулалтын зардал ашгийн тооцоог хийлгүйгээр орон нутгийн чанартай авто замын төслийг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлуулж, хэрэгжүүлснээр улсын төсвөөс санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Хуульд заасан шаардлагыг хангаагүй байхад Засгийн газраас шийдвэр гаргаж, "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын төсөл"-ийн гүйцэтгэгчтэй "шууд гэрээ" байгуулсан нь Концессын тухай хуульд бүрэн нийцэхгүй байна.
- Концесс эзэмшигч "Хансуун зам" ХХК төслийн хөрөнгө оруулагч солигдсон талаар концессыг хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдээгүй, концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох арга хэмжээг аваагүйгээс хөрөнгө оруулалт саатаж, төслийг хэрэгжүүлэх хугацаа гэрээнд зааснаас 3.5 жилээр хоцорчээ.
- "Хансуун зам" ХХК авто замын барилгын ажлыг зураг төсөл, авто замын салбарт мөрдөгдөж буй норм, стандартыг баримтлан барьж ашиглалтад өгсөн байна.
- Захиалагч болон санхүүжүүлэгч байгууллагууд УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.7 дахь хэсэгт *"улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах"* гэж заасныг зөрчиж, концессын зүйлийг хэрэгжүүлж дуусаагүй байхад санхүүжилтийг олгосон байна.
- Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болох Үндэсний хөгжлийн газар нь концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, гэрээний ашиглалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хугацаанд нь гаргуулан авч тайлагнах үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй байна.

ГУРАВ. ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд:

- Төрийн өмчийн концессын зүйлд нийгэм, эдийн засгийн ач холбогдол багатай, үр ашиг муутай төсөл, арга хэмжээг хамруулдаггүй байх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.
- Концессын тухай хуулийг зөрчсөн холбогдох албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар арга хэмжээ авах.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

- Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг санхүүжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох.

Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд:

- "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг холбогдох хууль журамд нийцүүлэн санхүүжүүлэх.
- Концессын гэрээний хэрэгжилтэд Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д "Концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх" гэж заасныг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээ авах.

Хавсралт 1

Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл

/төгрөгөөр/

Зардлын нэр	Гэрээний үнэ	ҮХГ-аас хянасан гүйцэтгэл /2019.11.15/	Бодитоор гүйцэтгэлийн дүн	Зөрүү
А	1	2	3	4=3-1
Үйлдвэрлэлийн зохион байгуулалт	8,681,498.00	8,681,498.00	8,681,498.00	
Талбайн цэвэрлэгээ	91,840,520.00	92,397,182.49	99,635,783.30	7,795,263.30
Газар шорооны ажил	1,997,544,719.00	1,997,544,719.20	1,702,305,075.00	(295,239,644.00)
Суурийн ажил	856,236,798.00	850,709,214.00	851,816,449.20	(4,420,348.80)
Хашлага суурилуулах	23,237,830.00	10,441,934.00	10,441,934.00	(12,795,896.00)
Хучилтын ажил	1,794,126,537.00	1,794,126,537.00	2,025,489,166.80	231,362,629.80
Ус зайлуулах энгийн байгууламж, явган зам	198,161,329.00	244,427,217.90	159,997,738.00	(38,163,591.00)
Замын тоноглолын ажил	18,991,262.00	18,991,262.00	18,991,262.00	
Замын тэмдэглэгээ хийх	43,229,230.00	36,913,140.00	69,460,560.00	26,231,330.00
Хиймэл байгууламжийн ажил	863,206,647.02	571,160,995.90	569,531,860.10	(293,674,786.92)
Замын цэвэрлэгээ	422,979.98	422,981.60	422,981.60	1.62
Материалын шинжилгээний ажил	15,012,685.00	15,012,685.65	15,012,685.65	0.65
Барилга угсралтын ажлын зардлын дүн	5,910,692,035.00	5,640,829,367.74	5,531,786,993.65	(378,905,041.00)
НӨАТ	591,069,204.00	591,069,204.00	553,178,699.00	(37,890,505.00)
Магадалшгүй ажлын зардал	118,213,840.70	118,213,840.70	80,643,078.00	(37,570,762.70)
Захиалагчийн хяналтын зардал	115,120,375.00	115,120,375.00	240,000,000.00	124,879,625.00
Норм, нормативын сангийн шимтгэл	10,639,245.00	10,639,246.60	9,957,217.30	(682,027.70)
ДҮН	6,745,734,699.70	6,475,872,034.04	6,415,565,987.95	(330,168,711.75)
Гадна цахилгаан гэрэлтүүлгийн ажил	203,328,000.00	203,328,000.00	203,328,000.00	
Зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний зардал	2,971,201.30		72,060,781.00	69,089,579.70
ДҮН	6,952,033,901.00	6,679,200,034.04	6,690,954,768.95	(261,079,132.05)

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.